

## Маргааны товч:

“Таван богд хот пот” ХХК нь 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “Таван богд монгол грилл” ХХК-д нэгдсэн, мөн тус компани нь 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр “Жуулчин” ХХК руу нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдсан. Үүнтэй холбоотойгоор татвар төлөгч бүртгэлээс хасагдах зорилгоор 2018-2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацааны үйл ажиллагаандаа татварын хяналт шалгалт оруулах хүсэлтийг гаргасан байна.

Хариуцагч Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч У.Оюунбилэг, С.Тамираа нар нь “Таван богд хот пот” ХХК-ийн 2018.01.01-ний өдрөөс 2022.11.30-ны өдрийг дуусталх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийж, 2023.02.09-ний өдрийн НА-22230000013 дугаар нөхөн ногдуулалтын акт үйлджээ.

Маргааны үйл баримтын тухайд, “Таван богд хот пот” ХХК нь өөрийн данснаас Хонконгийн хуулийн дагуу үүсэн байгуулагдсан “Little Sheep Hong Kong Holdings” Co.ltd компанитай байгуулсан франчайзийн гэрээний үндсэн дээр тус компанийн дансанд 2018-2019 онд нийт 811,457,189.80 төгрөгийн эрхийн шимтгэлийн төлбөр шилжүүлсэн байдаг. Ийнхүү шилжүүлэхдээ “Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн холбогдох заалтыг үндэслэн эрхийн шимтгэлийн төлбөрт 10 хувиар татвар суутган төлжээ. Үүнийг хариуцагчийн зүгээс “Хонконг бол Хятадаас тусдаа өөрийн гэсэн татварын хууль тогтоомжтой тул дээрх хэлэлцээрийг Монгол Улсын болон Хонконгийн аж ахуйн нэгжийн хооронд хийсэн гэрээ, ажил, гүйлгээнд хэрэглэхгүй. Иймд нэхэмжлэгч нь Монгол Улсын хуулийн (Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын) дагуу 20 хувийн татвар суутган төлөх байтал 10 хувиар төлж, төлбөл зохих татварыг нийт 81,145,718.98 төгрөгөөр бууруулан тайлагнасан ...” гэж үзжээ.

Нэхэмжлэгчээс “... Маргаан бүхий акт нь 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хүчин төгөлдөр болсон байдаг. Гэтэл актыг хуульд заасан хугацаанд гардуулаагүй, нөхөн ногдуулалтын актыг бидэнд мэдэгдээгүй. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд компанийг төлөөлөх эрхгүй этгээдийг оролцуулсан. Татварын байцаагч нар нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн. Мөн “Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 3 дугаар зүйлийн (б) хэсэгт заасны дагуу газар зүйн утгаараа БНХАУ-ын бүх нутаг дэвсгэр орно, газар зүйн байршлын хувьд Хонконг нь бүхэлдээ БНХАУ-ын нутаг дэвсгэрт оршдог, тус улсын салшгүй нэгэн хэсэг мөн байх тул дээрх хэлэлцээрийг Монгол Улсын болон Хонконгийн аж ахуйн нэгжүүд хооронд хийсэн гэрээ, ажил гүйлгээнд ашиглах бүрэн боломжтой ...” гэсэн агуулгаар маргажээ.